



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/12/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 99019800 Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2024-03-24 № 1/24  
танай 2024-03-06 -ны № 1/24 -т

ГМӨСТ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН  
ЗАХИРАГЧ С.БААСАНДОРЖ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мөст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, хог хаягдлын хураамжийн орлогыг бодитой төлөвлөж батлаагүй, сумын ОНХС-ийн төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээ, тендерийн баримт бичигт баталгаа тусгаагүй, төсөл арга хэмжээг хүлээн авсан тухай акт үйлдээгүй, анхан шатны баримтууд бүрэн бус, гүйцэтгэлийн баримтад үндэслэн санхүүжилтийг олгоогүй, барьцаа аваагүй, хүлээн аваагүй төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгосон зэрэг зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Мөст сумын татварын орлогыг 575.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нийт орлогыг 23.9 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар давуулан биелүүлсэн, малын тоо толгойн албан татвар 9.4, шууд бус орлого 11.3, байгалийн ургамал ашигласны төлбөр 0.4, ан амьтны нөөц ашигласны төлбөр 16.7, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 0.8, газрын төлбөр 0.9, ус рашааны нөөц ашигласны төлбөр 0.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

**Аудитын гол асуудал**

Худалдан авах ажиллагааны тухай хууль, журамд заасны дагуу тайланд онд ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол, дук машиныг харьцуулалтын аргаар, 50 ковшийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Мөст сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 11/05 тогтоолоор Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2023 оны зорилтын хэрэгжилтийг "хангалттай" гэж үнэлэгджээ.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	647,441.8	637,965.2
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	179,510.9	204,783.8
33	<b>АВЛАГА</b>	245,118.0	195,998.4
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	182,509.5	192,961.1
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	40,303.4	44,222.0
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,390,493.6	1,970,370.2
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,390,493.6	1,970,370.2
39200	Биет хөрөнгө	1,277,195.2	1,857,343.2
39300	Биет бус хөрөнгө	113,298.4	113,027.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	2,037,935.4	2,608,335.5
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	14,790.3	3,213.6
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	14,790.3	3,213.6
41300	Өглөг	14,790.3	3,213.6
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	2,023,145.0	2,605,121.9
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,023,145.0	2,605,121.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	695,532.9	695,532.9
51200	Хуримтлагдсан үр дүн	672,497.6	1,254,474.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	655,114.5	655,114.5
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	2,037,935.4	2,608,335.5

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	1,287,708.10	2,089,269.20
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	618,748.30	571,052.50
110	Орлогын албан татвар	214,794.10	249,946.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	214,794.10	265,404.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(15,457.30)
113	Хөрөнгийн албан татвар	50,640.10	36,503.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	353,314.10	284,602.20
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	182,904.50	631,883.90
120	Нийтлэг татварын бус орлого	182,904.50	631,883.90
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	486,055.30	886,332.80
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	1,255,742.40	1,507,292.30
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,255,742.40	1,507,292.30
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,220,856.60	1,492,188.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	394,567.40	500,387.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,959.40	62,264.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,794.60	21,047.10
2104	Хангамж, бараа материалын зардал	230,526.10	552,552.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,078.60	2,926.80
2107	Томилолт, зочны зардал	3,282.10	8,316.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,360.70	148,252.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	306,287.60	196,441.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,885.80	15,103.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	31,965.80	581,976.90
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,835,735.90	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(4,803,770.10)	581,976.90

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,145,960.5	1,494,725.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	618,748.3	571,052.5
110	Орлогын албан татвар	214,794.1	249,946.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	214,794.1	265,404.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(15,457.3)
113	Хөрөнгийн албан татвар	50,640.1	36,503.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	353,314.1	284,602.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	54,460.6	66,646.9
1181	Газрын төлбөр	2,197.8	4,229.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	296,655.7	213,725.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,156.9	37,340.4
120	Нийтлэг татварын бус орлого	31,156.9	37,340.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	496,055.3	886,332.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	954,910.3	963,211.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	954,910.3	963,211.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	918,056.9	947,511.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	394,597.1	500,547.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,585.0	61,600.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,634.7	40,910.3
2104	Хангамж, бараа материалын зардал	17,934.7	28,059.3
2105	Нормативт зардал	333.0	466.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,614.3	7,204.5
2107	Томилолт, зочны зардал	3,282.1	8,316.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	120,003.6	133,868.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	205,072.4	166,537.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,853.3	15,699.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	191,050.3	531,514.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	195,545.8	506,241.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	195,545.8	506,241.7
2200	Дотоод эх үүсвэрээр	195,545.8	506,241.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(195,545.8)	(506,241.7)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(49,000.0)	-

23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	49,000.0	-
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	(53,495.5)	25,272.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	233,006.4	179,510.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	179,510.9	204,783.8

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,482,022.04	2,422,464.42	890,228.30	6,794,714.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,786,489.10)	(1,767,349.92)	4,586,039.40	32,200.39
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	695,532.95	655,114.50	5,476,267.70	6,826,915.14
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,803,770.13)	(4,803,770.13)
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	695,532.95	655,114.50	672,497.57	2,023,145.01
11	2023 оны 1-р сарын 1 – ээрх үлдэгдэл	695,532.95	655,114.50	672,497.57	2,023,145.01
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	695,532.95	655,114.50	672,497.57	2,023,145.01
19	Тайлант үеийн үр дүн	-	-	581,976.91	581,976.91
20	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	695,532.95	655,114.50	1,254,474.48	2,605,121.92

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,583,887.6	1,422,928.18
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	933,333.0	916,686.46
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	917,050.5	900,986.66
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	502,212.3	500,547.74
210101	Үндсэн цалин	274,523.8	254,806.86
210102	Нэмэгдэл	154,997.5	148,259.71
210104	Урамшуулал	11,623.0	12,068.72
210105	Гэрээт ажлын хөлс	61,068.0	85,412.46
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,776.5	61,600.94
210201	Тэтгэврийн даатгал	42,688.0	41,969.41
210202	Тэтгэмжийн даатгал	5,022.1	4,939.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,017.7	3,448.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,004.4	1,531.39
210205	Эрүүл мэндийн даатгал	10,044.3	9,711.96

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>138,184.2</b>	<b>127,898.62</b>
210301	Гэрэл, цахилгаан	33,511.9	35,083.44
210302	Түлш, халаалт	102,517.3	90,820.88
210303	Цэвэр, бохир ус	2,155.0	1,994.30
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,996.9</b>	<b>25,943.66</b>
210401	Бичиг хэрэг	2,997.4	2,944.70
210402	Тээвэр, шатахуун	19,564.4	19,563.86
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,435.1	3,435.10
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>502.6</b>	<b>466.50</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	502.6	466.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,486.5</b>	<b>13,453.50</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280.6	279.60
210604	Урсгал засвар	13,205.9	13,173.90
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,912.6</b>	<b>6,292.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,912.6	6,292.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>38,859.0</b>	<b>38,219.54</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,317.1	33,851.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99.4	-
210803	Даатгалын үйлчилгээ	145.0	97.95
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225.0	197.98
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30.0	30.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,437.5	1,437.50
210807	Газрын төлбөр	2,605.0	2,605.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>127,119.9</b>	<b>126,564.16</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,773.1	125,217.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,346.8	1,346.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,282.5</b>	<b>15,699.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,282.5</b>	<b>15,699.80</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,370.5	14,370.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,912.0	1,329.30
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>600,554.6</b>	<b>506,241.72</b>
221001	Их засвар	47,893.5	22,119.30
222001	Тоног төхөөрөмж	447,249.0	433,222.42
223001	Бусад хөрөнгө	105,412.1	50,900.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>50,000.0</b>	<b>-</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	50,000.0	-
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,583,887.6</b>	<b>1,453,048.38</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,442,170.5</b>	<b>1,420,197.98</b>

320001	Орон нутгийн төсвөөс	1,007,728.0	985,755.48
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	434,442.5	434,442.50
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>141,717.1</b>	<b>32,850.41</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.0	744.50
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	32,105.91
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	141,112.1	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	120,519.70
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	150,639.91
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>64</b>	<b>64</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>
610001	Төсвийн байгууллага	2	2
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>31</b>	<b>31</b>
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	8	8
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>31</b>	<b>31</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9
650010	Гэрээт ажилтан	4	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1	1
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1	1

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>276,763.3</b>	<b>46,524.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>276,763.3</b>	<b>46,524.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>276,763.3</b>	<b>46,524.6</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>1,275.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	-	1,275.4
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>2,115.6</b>
210402	Тээвэр, шатахуун	-	2,115.6
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>2,024.0</b>
210702	Дотоод албан томилолт	-	2,024.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,426.1</b>	<b>1,136.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,426.1	1,136.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>266,337.2</b>	<b>39,973.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	266,337.2	39,973.3
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>276,763.3</b>	<b>46,524.6</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>276,763.3</b>	<b>46,524.6</b>

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000.0	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	269,666.5	28,710.6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,096.8	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000.0	17,814.0

## ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 150,324.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 70,884.5 мянган төгрөгийн алдааг залруулан 27,850.3 мянган төгрөгийн албан шаардлага, 51,590.0 мянган төгрөгийн зөвлөмж өглөө. Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн орлогыг 247.6 мянган төгрөгөөр дутуу,
- ОНХС-ийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1026.9 мянган төгрөгөөр төсвийн хэлбэлзэл зөрүүтэй,
- Etailan-д сумын ЗДТГ-ын төсвийн 65,400.0 мянган төгрөгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг ТТЗ-ын тайланд үзүүлэлт буруу сонгон нэгтгэсэн,
- ТТЗ-ын нэгтгэсэн тайланд ЗДТГ-ын 4,210.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авснаар нэгтгэснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 79,440.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 9,790.3 мянган төгрөгийн мянган төгрөгийн албан шаардлага, 69,650.0 мянган төгрөгийн 6 зөвлөмж өглөө.

### 3.1 Албан шаардлага

#### 3.1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн зардалтай холбоотой асуудал

Аймгийн болон сумын ОНХС-ийн хөрөнгөөр багийн дарга нарт олгосон 5.000.0 мянган төгрөгийн 5 мотоциклыг данс бүртгэлд тусгаагүй, тоглоомын талбайн 2022 оны үлдэгдэл 4,790.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 2023 оны төсөвт батлахгүйгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д "Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ.", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

### 3.2 Зөвлөмж

#### 3.2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагаа зохион байгуулж санхүүжилт олгохдоо анхан шатны баримт, гүйцэтгэлийн баримтуудад үндэслэн санхүүжилт олгоогүй, гэрээ дүгнээгүй, зарим төсөл арга хэмжээг акт үйлдэж ашиглалтад хүлээн аваагүй **36,800.0** мянган төгрөгийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиадуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүжилт олгосон нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 4.3-д заасан “Гүйцэтгэлийн санхүүжилт, түүний ангилал, бүрдүүлэх материал.”-ын жагсаалтад заасан 4.3.4-д заасан эхний, 4.3.5-д заасан дундын, 4.3.6-д заасан эцсийн санхүүжилт олгоход бүрдүүлэх баримт бичгүүдийн дагуу санхүүжилт олгоогүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмыг мөрдөж ажиллах.

### **3.2.2 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** ОНХС-ийн хөрөнгөөр ЭМТ-д **14,790.0** мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авахдаа тусгай зөвшөөрөлгүй, үйл ажиллагааны чиглэл таарахгүй компаниас худалдан авалт хийсэн нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.23-д “эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага” гэж эмийн сан, эрүүл мэндийн байгууллага болон мал эмнэлгийг эм, эмнэлгийн хэрэгслээр бөөний үнээр хангах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг; 6 дугаар зүйлийн 6.2-д “Энэ хуулийн 6.1-д заасан төрийн зохицуулалтыг дараах үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ”, 6.2.2-д “үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Тусгай зөвшөөрөлгүй компаниас эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахгүй байх,

### **3.2.3 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Худалдан авах ажиллагаа зохион байгуулж ажил гүйцэтгүүлж гэрээ байгуулахдаа гэрээнд болон тендерийн баримт бичигт баталгааг тусгаагүй, санхүүжилтээс барьцаа авч үлдээгүй нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 4.2.2.5-д “Төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх;”, 4.2.2.6-д “Чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг гүйцэтгэл тус бүрээс, эсхүл эцсийн буюу бүрэн санхүүжилтээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу суутган барьцаа хөрөнгийн дансанд байршуулах асуудлыг тухайн төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгасан байх;” гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журам, Барилгын тухай хуулийн дагуу барилга байгууламж, засвар үйлчилгээний ажлуудын гэрээнд баталгаат хугацаа, барьцаа зайлшгүй тусган, тооцож ажиллах.

### **3.2.4 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Гэрээнд заасны дагуу хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн зээлд алданги тооцоогүй Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.1.5-д “хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги;”, 10.1-д “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.” гэж заасан нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцож ажиллах

### 3.2.5 Зардлын төлөвлөлт, зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд төсвийн тодотголоор давсан орлогоос ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах арга хэмжээний хүрээнд туршлага судлах сургалтад хөрөнгө төлөвлөн баталж 18,060.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн төсвийг бодитой төлөвлөх, хүрэх үр дүн тодорхой арга хэмжээнд хөрөнгө зарцуулах, 2024 оны төсөвт төлөвлөхгүй байх

### 3.2.6 Орлого бүрдүүлэлт, төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны 07 дугаар тогтоолоор “Хог хаягдлын хураамжийн хэмжээ”-г айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгж бусад үйлчилгээний газрууд жилд төлөх хэмжээг тогтоон баталсан, орлогыг бодитой төлөвлөж батлаагүй нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 23.8-д “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.12-д “хог хаягдлын үйлчилгээний хураамж”, Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8-д “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хог хаягдлын хураамжийн орлогыг бодитой төлөвлөн батлах, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллах

Өгсөн зөвлөмж: Хог хаягдлын хураамжийн орлогыг бодитой төлөвлөн батлах, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 06 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### Дөрөв. Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
ИТХ	2	133,134.4			2	133,134.4	2	133,134.4				
ЗДТГ	6	18,627.9	2	14,000.0	4	4,627.9	6	18,627.9				
Хоршоо хөгжүүлэх сан	1	247.6			1	247.6	1	247.6				
ОНХС	1	1,026.9			1	1,026.9	1	1,026.9				
ТТЗ	2	69,610.0			2	69,610.0	2	69,610.0				
<b>Дүн</b>	<b>12</b>	<b>222,646.8</b>	<b>2</b>	<b>14,000.0</b>	<b>10</b>	<b>208,646.8</b>	<b>12</b>	<b>222,646.8</b>	-	-	-	-

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ИТХ	-	-								-	-	-	-
ЗДТГ	1	-					1						
Хоршоо хөгжүүлэх сан	1	-					1						
ОНХС	4	61,380.3			1	9,790.3	3	51,590.0					
ТТЗ	2	18,060.0					2	18,060.0					
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>79,440.3</b>	-	-	1	9,790.3	7	69,650.0	-	-	-	-	-

**ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

№	байгууллагын нэр	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	6	7	8	9	
1	ИТХ	1		1						
2	ЗДТГ	1		1						
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1						
4	ОНХС	1		1	-		-		-	
	<b>НИЙТ</b>	4	-	4	-	-	-		-	